

ШУТИС-ийн багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн нь 2017-2018 оны хичээлийн
жилийн ажлын мэдээлэл

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл нь 2017-2018 оны хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаа гүйцэтгэж, ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн тодорхой нэр бүхий 7 багш, ажилтантай холбоотой доор дурьдсан ёс зүйн зөрчлийн талаар ирсэн өргөдөл, гомдлын асуудлыг судалж, дүгнэлт гарган их сургуулийн хэмжээнд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын дагуу арга хэмжээ авах саналыг сургуулийн захиргаанд тавьж шийдвэрлүүлээ. Үүнд:

- Бусдын зохиол бүтээл, судалгааг санаатайгаар хууль бусаар өөрийн болгож хэвлүүлсэн;
- Хамт ажиллагчдын мэргэжлийн талаар болон хувийн зан чанарын дутагдлын талаар оюутнуудтай болон тэдний дэргэд ярилцсан;
- Бусад багш нарыг ажил үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс нөлөөлж, оюутны үнэлгээг заасан;
- Хувийн шалтгаанаар оюутны санал бодол, ухамсарт хүчээр нөлөөлсөн;
- Хамт ажиллагчидтайгаа хүндэтгэлгүй харилцаж, аливаа асуудлыг эв зүйгээр шийдэж чадаагүй;
- Суралцагчийг үг, хэлээр гутаан доромжилсон, дорд үзсэн;
- Өөрийн давуу байдлаа ашиглан бусдыг сэтгэл зүйн дарамтанд оруулсан;
- Багш, оюутны хоорондын харилцаанд харилцан хүндэтгэлийг эрхэмлээгүй.

ШУТИС-ийн багш, ажилтнуудад ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллахыг уриалж байна.

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл